



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.МӨНХСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020 10 01 № 22

Асуулт тавих тухай

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхэд, гэр бүл, залуучуудын талаар баримтлах бодлого, хууль, эрх зүйн орчныг сайжруулахад онцгойлон анхаарч ажилласны үр дүнд хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг шинээр батлан хэрэгжүүлж байгаа хэдий ч сүүлийн үед нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл ихээр үйлдэгдэж, хүүхэд, эмэгтэйчүүд тэдгээрийн золиос болох явдал ихээр гарах боллоо.

Хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг асуудлуудад салбар хоорондын уялдааг сайжруулах, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, ард иргэдийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх шаардлага байсаар байгаа тул Улсын Их Хуралд "Хүчирхийлэлтэй тэмцэх лобби" бүлэг байгуулан ажиллаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.7-д тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг байна. Асуултын хариуг 2017-2020 оны байдлаар гарган ирүүлнэ үү.


- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаарх тоон мэдээлэл, статистик;
- Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалан гарсан осол гэмтлийн тандалт, мэдээлэл;
- Осол гэмтэл, өвчлөлд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөөлөл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.БАЯРСАЙХАН



2020000044